

Япон улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр

Тэтгэлэгт хөтөлбөрөөр суралцах хугацаа: Бэлтгэл ангид 1 жил, үндсэн ангид 4 жил (нийт 5 жил)

Анагаах, Шүд, Мал эмнэлэг, Эм зүй бол 6 жил суралцаж бакалаврын зэрэг авах боломжтой.

Бэлтгэл сургалт

Оюутнууд эхний 1 жилийн хугацаанд Токиогийн Гадаад судлалын их сургууль, эсвэл Осакагийн их сургуулийн дэргэдэх Япон хэлний сургалтын төвд япон хэлний эрчимт сургалт болон бусад бэлтгэл сургалтад хамрагдана.

Бэлтгэл сургалтыг төгссөн оюутнууд нь Японы Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хуваарилсан их дээд сургуулийн элсэлтийн шалгалтыг өгч тэнцсэний дараа тухайн их, дээд сургуульд элсэж орно. Харин Японы Боловсрол, шинжлэх ухааны яам элсэн орох их, дээд сургуулийг шийдэхдээ Японы их, дээд сургуульд элсэх эхний шалгалтын дүн, япон хэл болон бэлтгэл сургалтын дүн, Японд суралцах мэргэжил, тухайн их

Сонгон шалгаруулалтын үед өгөх шалгалт:

Япон хэл, Англи хэл, Математик,

байгалийн ухаан бол мөн Хими, Физик (А) / Биологи (В)

Тэтгэлгийн хэмжээ: Сар бүр 117,000 иен

Тэтгэлэг олгох хугацаа: Суралцаж буй хугацаанд

Сургалтын төлбөр, хоёр талын нисэх онгоцны тийзгийг Японы Засгийн газар хариуцна.

Тавигдах шаардлага:

- Монгол Улсын иргэн байх
- 1997 оны 4 дүгээр сарын 2-ний өдрөөс хойш төрсөн байх
- Өргөдөл гаргах жилд Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн /12-р ангийн/ сурагч байх, эсвэл дотоодын их дээд сургуулийн 1-2 дугаар курсийн оюутан байх
- ЕБС-ийн сүүлийн 3 жилийн голч оноо 90 буюу түүнээс дээш байх, Их сургуулийн оюутан бол голч дүн 3.5 буюу түүнээс дээш байх /Дүнгийн жагсаалтад ЕБС-ийн сүүлийн 3 жилийн голч онооны дунджийг тодорхой бичсэн байх/
- Бие, сэтгэцийн хувьд эрүүл байх
- Цэргийн албан хаагч биш байх.
- Өмнө нь Япон улсын Засгийн газрын тэтгэлгээр суралцаж байгаагүй байх.
- Бусад байгууллагаас тэтгэлэг аваагүй, эсвэл тэтгэлэг авах төлөвлөгөөгүй байх.

Бүртгэл: Жил бүрийн IV-V сард явагдах бөгөөд бүрдүүлэх материалыг цахимаар болон шуудангаар гэсэн хоёр хэлбэрээр хүлээн авах бөгөөд бүртгэлийн материалыг хүлээн авмагц Элчин сайдын яамнаас “материал хүлээн авсан” тухай цахим шуудангаар мэдэгддэг.

Бүрдүүлэх бичиг баримт:

- Хүсэлт (Тогтсон маягт)
- Их сургуульд шууд элсэн орох хүсэлт (Тогтсон маягт)
- Сурлагын дүн
- ЕБС-ийн тодорхойлолт
- Хариуцсан багш эсвэл сүүлд төгссөн сургуулийн захирлын тодорхойлолт
- Цээж зураг (Зургийн ард талд нэрээ бичиж, хүсэлтийн маягтад наах)
- Гадаад хэлний шалгалтын гэрчилгээ (япон хэл, англи хэлний шалгалтын гэрчилгээ байгаа тохиолдолд илгээнэ үү)

Сонгон суралцах мэргэжлийн чиглэлүүд:

Бүртгэлийн үед доорх жагсаалтаас 3-ыг сонгох боломжтой.

Нийгмийн ухаан	Нийгмийн ухаан А 文科系A	Laws 法学 Politics 政治学 Pedagogy 教育学 Sociology 社会学 Literature 文学 History 史学 Japanese language 日本語学 Бусад мэргэжил その他
	Нийгмийн ухаан В 文科系B	Economics 経済学 Business Administration 経営学
Байгалийн ухаан	Байгалийн ухаан А 理科系A	<u>Science 理学系</u> -- Mathematics 数学 -- Physics 物理 -- Chemistry 化学 <u>Electric and Electronic Studies 電子電気系</u> -- Electronics 電子工学 -- Electrical Engineering 電気工学 -- Information Engineering 情報工学 <u>Mechanical Studies 機械系</u> -- Mechanical Engineering 機械工学 -- Naval Architecture 造船学 <u>Civil Engineering and Architecture 土木建築系</u> -- Civil Engineering 土木工学 -- Architecture 建築工学 -- Environmental Engineering 環境工学 <u>Chemical Studies 化学系</u> -- Applied Chemistry 応用科学 -- Chemical Engineering 化学工学 -- Industrial Chemistry 工業化学 -- Textile Engineering 繊維工学 <u>Бусад мэргэжил その他</u> -- Metallurgical Engineering 金属工学 -- Mining Engineering 鉱山学 -- Maritime Engineering 商船学 -- Biotechnology 生物工程

	Байгалийн ухаан В 理科系B	<u>Agricultural Studies 農学系</u> -- Agriculture 農学 -- Agricultural Chemistry 農芸化学 -- Agricultural Engineering 農業工学 -- Animal Science 畜産学 -- Veterinary Medicine 獣医学 -- Forestry 林学 -- Food Science 食品学 -- Fisheries 水産学 <u>Hygienic Studies 保健学系</u> -- Pharmacy 薬学 -- Hygienics 保健学 -- Nursing 看護学 <u>Science 理学系</u> -- Biology 生物学
	Байгалийн ухаан С 理科系C	-- Medicine 医学 -- Dentistry 歯学

- Та өргөдлийн маягыг зөвхөн англи, эсвэл япон хэлээр бөглөж өгнө үү. Монгол хэлээр үйлдэгдсэн бичиг баримтуудыг англи, эсвэл япон хэлэнд хөрвүүлэх шаардлагатай.
- Илгээх бичиг баримтын эх хувь (тус бүр 1 ш.)-ийг бүрдүүлж илгээнэ (хуулбар шаардахгүй).
- Шуудангаар материал илгээх бол материалыг үдэхгүй, бүрдүүлэх материалын дэс дарааллын дагуу дугтуйд хийнэ үү.
- Ярилцлагын шалгалтанд тэнцсэн хүнээс эрүүл мэндийн бичиг авна.
- Сурлагын дүн болон сургуулийн тодорхойлолтын тухайд
- ЕБС болон их/дээд сургуулиас олгодог тамга тэмдэг, гарын үсэг бүхий тодорхойлолт, их/дээд сургуулийн хувьд тухайн сургуулийн ТҮЦ машинаас олгох тодорхойлолт байж болно.
- Нотариатаар баталгаажуулаагүй бичиг баримтыг хүлээн авах ч хөл хорионы дараа заавал баталгаажуулах шаардлагатай.
- Хүлээн авсан материалыг буцаах боломжгүй. Зөвхөн сонгон шалгаруулалтад тэнцэж шалгарсан хүмүүсээс бичиг баримтын эх хувийг шаардах болно. Иймд материалаа цахим шуудангаар илгээх тохиолдолд шалгаруулалт дуустал эх хувиа хадгалж байхыг анхааруулж байна.
- Ахлах сургуулийн сурагч сүүлийн 3 жилийн дүнгийн тодорхойлолт, их сургуулийн оюутан бол ахлах сургуулийн 3 жилийн дүн болон их сургуулийн дүнгийн тодорхойлолтыг хамт илгээх шаардлагатай.
- Дүнгийн тодорхойлолтод дундаж оноо/дүн(GPA)-г тооцож гаргасан эсэхийг шалгана уу. Сурлагын оноо/дүнгийн дундаж(GPA)-ийг тооцож гаргаагүй бол материалыг хүлээн авахгүй.

Дэлгэрэнгүй мэдээлэл болон өмнөх жилүүдэд ирсэн шалгалтын материал болон хариунуудыг дараах холбоосуудаар орж татаж авах боломжтой.

Холбоос: <https://www.studyinjapan.go.jp/en/planning/scholarship/application/examination/>

Холбоос: https://www.mn.emb-japan.go.jp/itpr_ja/studyinjapan2022_mon_2.html